



СТЕП НОМАДС ЖУУЛЧНЫ БААЗ

Албан тушаал: Баазын менежер

Танд олгож буй 10 онцлог БОЛОМЖ, ДАВУУ ТАЛ:

1. Сурсан мэдснээ амьдралд хэрэгжүүлэх, чадвараа сорих сайхан боломж,
2. Байнга жуулчидтай харилцаж хэлний мэдлэгээ сайжруулан зүгшрүүлэх,
3. Улаанбаатар хотоос холгүй, үзэсгэлэнт Гүн-Галуутайн байгалийн нөөц газрын эрүүл агаар, гол устай байгалийн сайхан орчинд ажиллах,
4. Эерэг энерги хуримтлагдсан, дуу чимээ, стрессээс хол орчинд эрүүлжиж чийрэгжих
5. Аялал жуулчлалын үйлчилгээ, сэтгэл ханамжийн салбарт туршлага хуримтлуулах
6. Зөвлөж туслах туршлагатай удирдлага, гар сэтгэл нийлсэн багтай хамтран ажиллаж суралцаж, дадлагажих,
7. Монголын аялал жуулчлалын салбарт хэдийн танигдсан, олон үйлчлүүлэгч, түнштэй, өндөр нэр хүндтэй компанид ажиллах
8. Мөнгөө хуримтлуулах (жуулчны бааз дээр ажиллах үед ажлын хөлс тань огт үрэгдэгдэхгүй, танаас ямарч зардал гарахгүй, байр хоолыг компани хариуцна)
9. Өрсөлдөхүйц цалин (300-600.0 мянга) + жилийн эцэст бонус авах,
10. Цаашид өсч дэвших, дотоод гадаадад суралцахад дэмжлэг авах

Гүйцэтгэх үндсэн үүрэг:

1. Баазын үйлчилгээний удирдлага (service hospitality)
2. Хүний нөөцийн удирдлага, хяналт
3. Зар сурталчилгаа ба маркетинг
4. Хамтрагч, үйлчлүүлэгчийн захиалгыг хүлээн авах, тодруулга өгөх, баталгаажуулах
5. Хамтрагч түншүүдийг олох, гэрээ байгуулах

Тавигдах шаардлага:

1. Их дээд сургууль төгссөн, 24-30 хүртэлхи насны эмэгтэй (аялал жуулчлал, бизнесийн удирдлага, маркетингийн чиглэлийн мэргэжилтэй бол сайн)
2. Англи хэлний яриа бичгийн чадвар сайтай,
3. Удирдан зохион байгуулах мэдлэг, авъяастай эсвэл мэргэжил, туршлагатай
4. 3-аас доошгүй жил тогтвор суурьшилтай ажиллах
5. Зуны улиралд (5-10 сар хүртэл) хөдөө ажиллах бүрэн боломж нөхцөлтэй, 10 сараас дараа оны 5 сар хүртэл хотод оффист ажиллах,

Та энэ ажлын байранд тавигдаж буй шаардлагыг хангаж байгаа бол, бидний санал болгож байгаа ажил үүргийг хэрэгжүүлж чадна гэж өөртөө итгэж байгаа бол анкетаа даруйхан дараахи хаягаар илгээнэ үү? booking@SteppeNomads.com

Ажиллах жуулчны баазынхаа талаар илүү дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл <http://www.MongoliaGerCamp.com> хаягаар орж танилцана уу. Утас: 9191-3498